

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/115/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаангом хот

2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Б.Одгэрэл

Утас: 70453721, Цахим хаяг: Odgerelb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

додд. од. дс № МБА-2022/115/НА-СТА-ТУС
танай _____-ны № _____-т

УЛААНГОМ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.БАДАМХАТАН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200291

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>87,388,589.33</u>	<u>113,692,679.83</u>
33	АВЛАГА	00.00	2,810,648.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	1,640,648.00
335	Бусад авлага	00.00	1,170,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	1,170,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	87,388,589.33	110,882,031.83
351	Түүхий эд материал	11,825,494.60	6,728,827.60
35110	Тусгай зориулалттай материал	11,778,794.60	6,663,427.60
35130	Эм боох материал	46,700.00	65,400.00
354	Хангамжийн материал	75,563,094.73	104,153,204.23
35410	Бичиг хэргийн материал	136,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	2,873,250.00	1,769,500.00
35450	Барилгын засварын материал	573,500.00	300,000.00
35470	Бусад хангамжийн материал	71,980,344.73	102,083,704.23
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,224,481,051.35</u>	<u>2,463,494,450.38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>2,224,481,051.35</u>	<u>2,463,494,450.38</u>
392	Биет хөрөнгө	1,473,427,717.97	1,712,641,116.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,239,875,331.00	1,502,458,955.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-46,223,209.92	-60,244,808.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,350,000.00	31,350,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-326,562.50	-3,265,625.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	379,420,875.70	432,511,875.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-266,035,698.50	-298,538,634.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	153,944,361.90	160,090,343.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-64,515,647.27	-81,365,585.34
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,705,900.00	9,705,900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,705,900.00	-9,705,900.00
39217	Ном	45,938,267.56	29,644,595.93
393	Биет бус хөрөнгө	751,053,333.38	750,853,333.40
39301	Програм хангамж	2,550,000.00	2,850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,716,666.62	-2,216,666.60
39303	Бусад биет бус хөрөнгө	750,220,000.00	750,220,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,311,869,640.68</u>	<u>2,577,187,130.21</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,716,104.00</u>	<u>241,356.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,716,104.00	241,356.00
413	Өглөг	2,716,104.00	241,356.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	141,356.00
4136	Бусад өглөг	2,716,104.00	100,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,716,104.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	100,000.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,309,153,536.68</u>	<u>2,576,945,774.21</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,309,153,536.68	2,576,945,774.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,368,870,237.65	1,368,870,237.65
51101	Өмч: - төрийн	1,368,870,237.65	1,368,870,237.65
512	Хуримтлагдсан үр дүн	711,944,349.37	979,736,586.90
51210	Өмнөх үеийн үр дүн	711,944,349.37	711,944,349.37
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	267,792,237.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	228,338,949.66	228,338,949.66
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,311,869,640.68</u>	<u>2,577,187,130.21</u>

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,903,339,251.48	2,003,851,267.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,896,270,251.48	1,992,351,711.46
120	Нийтлэг татварын бус орлого	177,474,951.48	339,465,811.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	300,600.00	259,609.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,600.00	259,609.00
122	Тусламжийн орлого	190,900,100.00	201,948,100.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,527,895,200.00	1,450,937,800.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,527,895,200.00	1,450,937,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,069,000.00	11,499,556.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,069,000.00	11,499,556.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,569,000.00	10,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	899,556.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,783,401,428.89	1,716,195,939.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,783,401,428.89	1,716,195,939.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,695,845,837.89	1,664,102,791.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,229,301,654.00	1,184,465,082.00
210101	Үндсэн цалин	829,774,849.00	780,575,499.00
210102	Нэмэгдэл	292,743,120.00	328,314,883.00
210104	Урамшуулал	106,783,685.00	75,574,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	154,456,718.00	156,545,531.00
210201	Тэтгэврийн даатгал	106,874,618.00	108,886,099.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,017,657.00	11,935,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,611,376.00	9,466,732.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,395,813.00	2,387,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,557,254.00	23,870,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,426,320.00	192,614,380.00
210301	Гэрэл, цахилгаан	5,439,518.00	4,425,826.00
210302	Түлш, халаалт	164,597,506.00	182,795,036.00
210303	Цэвэр, бохир ус	3,389,296.00	5,393,518.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,709,034.20	42,020,983.00
210401	Бичиг хэрэг	6,638,100.00	5,110,366.00
210402	Тээвэр, шатахуун	1,168,320.00	2,134,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	892,450.00	1,588,300.00
210404	Ном, хэвлэл	20,000.00	6,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,701,300.00	2,001,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,703,650.00	6,314,800.00

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	17,585,214.20	24,865,367.00
2105	Нормативт зардал	7,247,600.00	429,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	926,600.00	429,200.00
210502	Хоол, хүнс	6,321,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,054,000.00	9,384,900.00
210604	Урсгал засвар	12,054,000.00	9,384,900.00
2107	Томилолт, зочны зардал	555,000.00	641,000.00
210702	Дотоод албан томилолт	555,000.00	641,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,474,900.00	3,130,830.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,256,400.00	1,856,430.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	806,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	642,500.00	418,000.00
210807	Газрын төлбөр	00.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,620,611.69	74,870,885.34
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	938,000.00	8,057,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	79,682,611.69	66,813,535.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,555,591.00	52,093,148.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,740,500.00	43,861,150.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,403,500.00	41,739,150.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,337,000.00	2,122,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	8,231,998.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	8,231,998.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,815,091.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,815,091.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>119,937,822.59</u>	<u>287,655,328.12</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,123,337.10	19,863,090.59
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,533,337.10	19,863,090.59
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	590,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,123,337.10	-19,863,090.59
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>117,814,485.49</u>	<u>267,792,237.53</u>

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,729,305,900.00</u>	<u>1,664,645,065.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,719,095,900.00	1,653,145,509.00
120	Нийтлэг татварын бус орлого	300,600.00	259,609.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	300,600.00	259,609.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,600.00	259,609.00
122	Тусламжийн орлого	190,900,100.00	201,948,100.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,527,895,200.00	1,450,937,800.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,527,895,200.00	1,450,937,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,210,000.00	11,499,556.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,210,000.00	11,499,556.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,569,000.00	10,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	899,556.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,729,305,900.00</u>	<u>1,664,645,065.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,729,305,900.00	1,664,645,065.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,639,786,859.00	1,611,381,917.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,228,057,892.00	1,186,706,510.00
210101	Үндсэн цалин	802,119,229.00	768,583,610.00
210102	Нэмэгдэл	319,154,978.00	342,548,200.00
210104	Урамшуулал	106,783,685.00	75,574,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,664,697.00	158,186,179.00
210201	Тэтгэврийн даатгал	106,082,627.00	110,445,379.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,017,657.00	11,935,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,614,346.00	9,548,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,395,813.00	2,387,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,554,254.00	23,870,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,193,000.00	192,847,700.00
210301	Гэрэл, цахилгаан	5,439,518.00	4,425,826.00
210302	Түлш, халаалт	164,364,186.00	183,028,356.00
210303	Цэвэр, бохир ус	3,389,296.00	5,393,518.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,797,770.00	24,525,456.00
210401	Бичиг хэрэг	865,800.00	1,631,956.00
210402	Тээвэр, шатахуун	733,320.00	2,134,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	807,450.00	1,588,300.00
210404	Ном, хэвлэл	782,900.00	783,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,540,000.00	2,600,100.00

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,068,300.00	15,787,200.00
2105	Нормативт зардал	7,842,500.00	1,530,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	364,500.00	364,400.00
210502	Хоол, хүнс	6,321,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,157,000.00	1,165,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,007,100.00	32,596,382.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,300,000.00	18,000,000.00
210602	Тавилга	00.00	5,495,982.00
210604	Урсгал засвар	17,707,100.00	9,100,400.00
2107	Томилолт, зочны зардал	555,000.00	641,000.00
210702	Дотоод албан томилолт	555,000.00	641,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,744,900.00	3,546,330.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,526,400.00	1,971,930.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	806,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	642,500.00	718,000.00
210807	Газрын төлбөр	00.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,924,000.00	10,802,060.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,924,000.00	10,802,060.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,519,041.00	53,263,148.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,703,950.00	45,031,150.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,461,950.00	41,739,150.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,242,000.00	3,292,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	8,231,998.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	8,231,998.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,815,091.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,815,091.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	618,650,237.65	367,596,036.93	110,153,627.64	1,096,399,902.22
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	618,650,237.65	367,596,036.93	110,153,627.64	1,096,399,902.22
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-71,344,213.31	-71,344,213.31
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,368,870,237.65	228,338,949.66	711,944,349.37	2,309,153,536.68
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,368,870,237.65	228,338,949.66	711,944,349.37	2,309,153,536.68
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,368,870,237.65	228,338,949.66	711,944,349.37	2,309,153,536.68
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	267,792,237.53	267,792,237.53
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,368,870,237.65	228,338,949.66	979,736,586.90	2,576,945,774.21

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,656,885,900.00	1,644,913,511.00	11,972,389.00	99.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,656,885,900.00	1,644,913,511.00	11,972,389.00	99.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,611,132,500.00	1,601,282,361.00	9,850,139.00	99.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,193,520,000.00	1,186,706,510.00	6,813,490.00	99.4
210101	Үндсэн цалин	775,397,100.00	768,583,610.00	6,813,490.00	99.1
210102	Нэмэгдэл	342,548,200.00	342,548,200.00	0.00	100.0
210104	Урамшуулал	75,574,700.00	75,574,700.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161,125,200.00	158,186,179.00	2,939,021.00	98.2
210201	Тэтгэврийн даатгал	113,384,400.00	110,445,379.00	2,939,021.00	97.4
210202	Тэтгэмжийн даатгал	11,935,200.00	11,935,200.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,548,100.00	9,548,100.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,387,100.00	2,387,100.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	23,870,400.00	23,870,400.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	192,847,700.00	192,847,700.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	4,399,600.00	4,425,826.00	-26,226.00	100.6
210302	Түлш, халаалт	182,856,000.00	183,028,356.00	-172,356.00	100.1
210303	Цэвэр, бохир ус	5,592,100.00	5,393,518.00	198,582.00	96.4
2104	Хангамж, бараа материалын зардал	20,325,900.00	20,325,900.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	632,400.00	632,400.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,234,200.00	1,234,200.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,588,300.00	1,588,300.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	783,700.00	783,700.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,300,000.00	2,300,100.00	-100.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,787,300.00	13,787,200.00	100.00	100.0
2105	Нормативт зардал	1,530,400.00	1,530,300.00	100.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	364,500.00	364,400.00	100.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,165,900.00	1,165,900.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,108,700.00	32,096,382.00	12,318.00	100.0

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	17,500,000.00	17,500,000.00	0.00	100.0
210602	Тавилга	5,508,300.00	5,495,982.00	12,318.00	99.8
210604	Урсгал засвар	9,100,400.00	9,100,400.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	388,000.00	321,000.00	67,000.00	82.7
210702	Дотоод албан томилолт	388,000.00	321,000.00	67,000.00	82.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,409,400.00	2,391,330.00	18,070.00	99.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	833,400.00	816,930.00	16,470.00	98.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	806,400.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	719,600.00	718,000.00	1,600.00	99.8
210807	Газрын төлбөр	50,000.00	50,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6877200.00	6877060.00	140.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,877,200.00	6,877,060.00	140.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45753400.00	43631150.00	2,122,250.00	95.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,753,400.00	43,631,150.00	2,122,250.00	95.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,861,400.00	41,739,150.00	2,122,250.00	95.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,892,000.00	1,892,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,656,885,900.00	1,644,913,511.00	11,972,389.00	99.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,450,937,800.00	1,442,705,802.00	8,231,998.00	99.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,000,000.00	259,609.00	3,740,391.00	6.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	259,609.00	3,740,391.00	6.5

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		11,499,556.0	-11,499,556.0	
21	УРСГАЛ ЗАРДАЛ		11,499,556.0	-11,499,556.0	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		10,099,556.0	-10,099,556.0	
2104	Хангамж, бараа материалын зардал		4,199,556.0	-4,199,556.0	
210401	Бичиг хэрэг		999,556.0	-999,556.0	
210402	Тээвэр, шатахуун		900,000.0	-900,000.0	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		300,000.0	-300,000.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,000,000.0	-2,000,000.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		500,000.0	-500,000.0	
210601	Багаж, техник, хэрэгсэл		500,000.0	-500,000.0	
2107	Томилолт, зочны зардал		320,000.0	-320,000.0	
210702	Дотоод албан томилолт		320,000.0	-320,000.0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,155,000.0	-1,155,000.0	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,155,000.0	(1,155,000.0)	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		3,925,000.0	(3,925,000.0)	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		3,925,000.0	(3,925,000.0)	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,400,000.0	(1,400,000.0)	
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,400,000.0	(1,400,000.0)	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,400,000.0	(1,400,000.0)	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		11,499,556.0	(11,499,556.0)	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		11,499,556.0	(11,499,556.0)	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		11,499,556.0	(11,499,556.0)	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэх, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь тус байгууллагын 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,785,350.1 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 8,926.8 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,716,195.9 мянган төгрөгийн 0.5 хувиар буюу 8,581.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 6,864.8 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 239,013.4 мянган төгрөгөөр буюу 10.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	2,810.6	2,810.6
Бараа материал	91,988.2	115,491.6	23,503.4
Үндсэн хөрөнгө	2,219,871.5	2,458,884.9	239,213.4
Нийт хөрөнгө	2,311,869.6	2,577,187.1	265,317.5
Өр төлбөр	2,716.1	241.4	-2,474.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,309,153.5	2,576,945.7	267,792.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,311,869.6	2,577,187.1	265,317.5

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 2,810.6 мянган төгрөг болж 2,810.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд илүү шилжүүлсэн НДШ-ийн авлага болон боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд зохион байгуулагдах уралдааны шагналын мөнгийг хувь хүмүүст шилжүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 115,491.6 мянган төгрөг болж 23,503.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд бусад хангамжийн материал зарцуулагдаагүй үлдсэнтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,219,871.5 мянган төгрөг болж 239,213.4 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвийн хөрөнгөөр 24,573.7 мянган төгрөг, хандив болон бусад эх үүсвэрээс 301,116.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант онд 66,813.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцож, 19,863.1 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 241.4 мянган төгрөг болж 2,474.7 мянган төгрөгөөр буурсан нь ХХОАТ-ын өглөг барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,576,945.7 мянган төгрөг болж 267,792.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 100,512.0 мянган төгрөгөөр буюу 5.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өсөхөд Азийн хөл бөмбөгийн холбооноос мини хөл бөмбөгийн талбайг хийж өгсөн нь нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 67,205.5 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс буурахад цалин хөлс, гэрэл цахилгаан, бичиг хэрэг, урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардал буурсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,668,385.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,668,385.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 1,668,385.5 мянган төгрөгөөр буюу зардал бууруулахгүйгээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,668,385.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,388,170.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,450,937.8 мянга, орон нутгийн төсвөөс 201,948.1 мянган төгрөг авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 259.6 мянган төгрөг оруулж, нийт 1,644,913.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,644,913.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үндсэн үйл ажиллагааны данснаас 8,232.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,644,913.5 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар 11,500.0 мянган төгрөгийн орлого орж 11,500.0 мянган төгрөгийн зарлага гарсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 135, хугацаа хоцроосон 14 хугацаа болоогүй 2 мэдээлэл хүлээгдэж байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 58 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Боловсрол, шинжлэх ухааны яамны “Боловсрол чанарын шинэчлэл” төслийн хүрээнд хийгдээгүй ажлын санхүүжилт 1,170.0 мянган төгрөгийг 2 багшийн дансанд шилжүүлснийг санхүүгийн тайланд авлага тусгуулан залруулга хийлгэв.
2. Суутгаагүй тооцоогүй цалингийн урьдчилгааны 100.0 мянган төгрөгийг зардалд бүртгэсэн байсныг санхүүгийн тайланд авлага тусгуулан залруулга хийлгэв.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Улаангом сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	2	1,270.0	2	1,270.0						

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /Б.ОДГЭРЭЛ/

2022 оны 02 сарын 25-ны өдөр